

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Аймгийн Засаг дарга сумын Засаг дарга нартай сар бүрийн сүүлийн 7 хоногийн “Баасан” гарагийн 09 цагт “Хөвсгөлийн цаг” цахим хурлын зохион байгуулж байхаар товлосны дагуу 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр цахим хурлыг зохион байгуулж сумын Засаг дарга нарт цаг үеийн ажлын талаар мэдээлэл өгч, тэдний санал хүсэлтийг сонсон зарим асуудлыг шийдвэрлэн ажиллалаа.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2021 оны 04-р сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 9.2 тэр бум төгрөгний **1732** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2021 оны 03-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 9,225.6 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 9,027.5 сая төгрөг буюу 97.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл 2021 оны 03-р сарын мэдээгээр Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 30,225.2 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 17,548.0 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 9,027.5 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 609.0 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 613.7 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, Нийгмийн даатгалын сангийн төсвөөс тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 30,225.2 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 23,978.3 сая төгрөг буюу 79.3 % хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт энэ сард дутуу ирсэн.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **5,218.7** сая төгрөг өмнөх сараас **5.1** сая төгрөгөөр буурсан.

Нийт өглөг **779.2** сая төгрөг өмнөх сараас **132.7** сая төгрөгөөр өссөн.

Нийгмийн даатгалын хэлтэсийн сарын шуурхай мэдээ:

2021 оны 04 сарын байдлаар $\text{íëéãìëéí äààðäàëüí ñàíä}$ шимтгэлийн орлого 2282.8 ñàý төгрөг, $\text{ñàéí äóðóí äààðäóóëäã-ààñ}$ 260.1 ñàý $\text{ò°ãð°äëéí, øèìäýýëëí îðëíãí}$, нийт 2542.9 сая төгрөг буюу 120 % -èàð áëäë¿¿ëñýí байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

Төрөл	төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
Тэтгэвэр	1874.6	2237.8	119
Тэтгэмж	144.5	178	123.2
ҮОМШӨ	73.1	89	121.7
ЭМД	0,0	0,0	0,0
ажилгүйдэл	29.9	38.1	127.4
дүн	2122.1	2542.9	120

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 571.8 сая төгрөг байна.

Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд :

Хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Хөвсгөл аймгийн хэмжээнд 5 суманд Коронавируст халдвар (COVID-19)-ын нийт батлагдсан тохиолдол 74 бүртгэгдэж үүнээс 68 тохиолдол нь бүрэн эдгэрч гэрийн ажиглалтанд шилжсэн бол 6 тохиолдол эрүүл мэндийн байгууллагад эмчлэгдэж байна. Дээрхи батлагдсан тохиолдлуудын явсан маршрут, гэр орон, тусгаарлан ажиглах байр, эрүүл мэндийн байгууллагуудад 2021 оны 04 сарын 10-ны өдрөөс 2021 оны 05 сарын 08-ны өдрүүдэд урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлт сумын эрүүл мэндийн төв, Зоонозын өвчин судлалын төв, Ган өрлөг мэргэжлийн байгууллагууд Мэргэжлийн хяналтын газрын өгсөн зөвлөмж чиглэлийн дагуу хийж мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нар хяналт тавин ажиллаа.

1.Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт

1.1.Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/10, А/133, А/146, А/157, А/158, А/162, А/187, А/200, А/201 дугаарт захирамжийн дагуу Цэцэрлэг, Мөрөн, Тариалан,Рэнчинлхүмбэ,Чандмань-Өндөр сумдууд Коронавируст халдвар (COVID-19)-ын халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын тархалтыг хязгаарлах зорилгоор халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байна.

1.2 Голомттой бүс нутгаас орж ирж байгаа хүнс, шатахуун, барилга, бусад чиглэлийн ачаа тээврийн 424 автомашин 7923 тн ачаанд аймгийн Мал эмнэлэгийн газар,АТҮТөв хамтран мэргэжлийн хяналтын газрын хяналтан доор ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажилласан.

2.Голомтын эцсийн халдваргүйжүүлэлт

2.1.Коронавируст халдвар (COVID-19)-ын батлагдсан тохиолдлын явсан маршрутын дагуу албан байгууллага, аж ахуйн нэгж, орон сууц, гэр байшин, тусгаарлах

байранд зааврын дагуу Мөрөн 85 объектод, 16032 мкв талбайд, Тариалан, 16 объектын 790 мкв, Рэнчинлхүмбэ 12 объектын 520 мкв талбай, Чандмань-Өндөр 6 объектын 210 мкв нийт 119 объектын 17552 метр квадрат, талбайд халдваргүйжүүлэлт хийсэн байна.

3. Дархлаажуулалтын явцын мэдээ.

Хөвсгөл аймаг дархлаажуулалтын I, II-р тунг тарих ажлыг 2021 оны 05 сарын 03-наас 2021 оны 05 сарын 10-ны өдрүүд ажлын хэсгийн гаргасан төлөвлөгөөний дагуу хийж дуусгахаар график гарган ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 1-р тунг 30110 иргэнд, II-р тунг өнөөдөр-6414 иргэнд, нийт-36521 буюу зорилтод хүн амын 41%-г вакцинжуулсан байна.

Онцгой байдлын чиглэлээр:

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Зах, худалдааны төвийн байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын” удирдамжийн хүрээнд Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Барилгын тухай, Барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02/, Барилга, байгууламжийн зураг төслийн галын аюулгүйн норм /БНБД 21-02-02/, Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02/, Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер /БНБД 41-01-02/, Цахилгаан техникийн ажил /БНБД 3.05.06.90/, Барилга, байгууламжийн гал унтраах автомат тоног төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/, Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/ зэрэг стандарт, техникийн нормативуудыг үндэслэн гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалтыг Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч-1, Гал түймрийн улсын хяналтын байцаагч-2 бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан.

Шалгалтын явцад 448 зөрчил илэрч 68 зөрчлийг үзлэг шалгалтын явцад засуулж, зөрчил дутагдлыг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн Заавал биелүүлэх албан шаардлага 41, Мэдэгдэл-4 бичиж өгч биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Мөрөн сумын Засаг дарга болон ЗДТГ-ын дарга, мөн 14 багийн Засаг дарга нарт Мөрөн сумын нутаг дэвсгэрт коронавирусын халдварт өвчин дэгдсэн үед хэрхэн ажиллах талаар заавар зөвлөмжийг ЭМГ-ын мэргэжилтний хамт өгч, баг тус бүр дээр хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж ажиллах сургалтыг зохион байгуулав.

Аймгийн Засаг даргын 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/158 дугаар захирамжаар Улаанбаатар хот болон голомтын бүсээс ирсэн ачаа тээврийн жолооч, түүнтэй хамт ирсэн зорчигчийг тусгаарлах үүргийг Онцгой байдлын газарт өгсөн. Үүргийн дагуу дээрх хугацаанд давхардсан тоогоор 134 жолооч болон зорчигчийг 365, Эдельвайс, Ахмадын сувилал, Бишрэлт зэрэг буудлуудад 1-5 хоногийн хугацаатай түр тусгаарлан ажилласан.

Улсын Онцгой комиссын 2021 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд Аймгийн Цагдаагийн

газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль, орчин аялал жуулчлалын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдтэй хамтран Ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээ хийж, үнэлгээгээр 3 сум маш их, 6 сум их, 2 сумд дунд зэрэгтэй үнэлэгдэв

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2021 оны 04 дүгээр сард объектын гал түймэр 8 суманд 8 удаа ахуйн хүрээнд гарсан байна.

2021 оны 04-р сарыг өмнөх оны 04 сартай харьцуулахад гал түймрийн тоо 53.6 хувиар буурсан үзүүлттэй байна.

Гэмт хэрэг, зөрчлийн чиглэлээр:

2021 оны 4 дүгээр сард 1309 гомдол, мэдээлэл шалгасан нь өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар өссөн дүнтэй байна. Үүнээс эрүүгийн гэмт хэрэг 187 бүртгэгдсэн нь мөн үеийнхээс 27.2 хувиар буурсан үзүүлэлт, илрүүлсэн зөрчил, шийдвэрлэлт 88263 байгаа нь өмнөх оны мөн үеэс 33,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

2021 оны 03 сарын байдлаар өссөн дүнгээр 41 хөмрөгийн 41 дансны 215 хадгаламжийн нэгжийн 21,251 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, үүнээс 39 хөмрөгийн 39 дансны 1174 хадгаламжийн нэгжийн 16763 хуудас баримтын тодорхойлон бичилтийг хийсэн байна.

Мөн өссөн дүнгээр 553 иргэнд захирамжлалын баримт бичгийн, 7 иргэнд цалингийн цэсний, 125 иргэнд малын А дансны лавлагаа, 252 иргэнд магадалгаа, тодорхойлолт гаргаж өгөх үйлчилгээ үзүүлсэн.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Боловсрол соёл, урлагийн газраас теле хичээл явагдаж буй хугацаанд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 16 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлж ажиллаж байна.

2020-2021 оны хичээлийн жилийн хоёрдугаар хагас жилийн хичээл, сургалтын үйл ажиллагаа 2 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн теле, цахим хэлбэрээр явагдахтай холбогдуулан цахим хурлыг зохион байгууллаа. Тус сургалтыг ЭМГ, МХГ, ГБХЗХГ-тай хамтран цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш ажилтан 348 хүнд цахим хэлбэрээр явуулж холбогдох зөвлөгөө зөвлөмжийг өгч ажилласан.

Танхимаар хичээллэх үед сургууль, цэцэрлэгийн орчныг мэргэжлийн байгууллагаар ариутгал хийлгэх, халдвар хамгаалал, аюулгүй байдлыг сахих, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөц бүрдүүлэх чиглэлээр нийт боловсролын байгууллагуудад чиглэл зөвлөмжийг хүргэж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа "Эх хэл-Эх багш" уралдааны бүтээлийн танилцуулгыг цахим хэлбэрээр түгээлээ.

Боловсрол, соёл, урлагийн газар, Мөрөн сумын Засаг даргын тамгын газар хамтран Мөрөн сумын ерөнхий боловсролын сургуулиудын захирлуудтай уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтаар Мөрөн сумын сургуулиудад тулгамдаж буй асуудал, сургуулиудын бүтэц, хэв, шинж, хамран сургалт, багшийн ёс зүйн талаарх асуудлаар санал солилцож цаашид сум, боловсролын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр хамтран ажиллахаар боллоо.

СӨБ, бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, чанар үр дүнг нэмэгдүүлэхэд талаар “Ахмад багш нарын холбоо”, “Захирлуудын холбоо”, “Дэлхийн Зөн” ОУБ, Залуу багш нарын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо, Эх нутгийн боловсрол зэрэг ТББ-уудын төлөөлөлтэй уулзалт ярилцлага зохион байгууллаа.

Тогтвортой хөгжлийг дэмжигч, олон нийт, сургуулийн түншлэлд суурилсан "Олон Улсын Эко Сургууль" хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэн ахисан түвшний шалгуур хангаж "Ногоон туг"-ны эзнээр Авьяас-8 сургууль, "Мөнгөн гэрэгэ"-гээр Б.Гантулга захиралтай Дэлгэрмөрөн сургуулийн хамт олон шагнагдлаа.

Боловсролын салбарын танхимын сургалтыг эхлэх бэлэн байдлыг хангах, сургууль цэцэрлэгийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор Улсын онцгой комисст яаралтай хүргүүлэх төсвийн тооцоо судалгааг сургууль, цэцэрлэг бүрээр нарийвчлан гаргаж цаг хугацаанд нь хүргүүлээ.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ЧИГЛЭЛЭЭР:

Нэг цэгийн үйлчилгээний төвийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан бэлгийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй хохирогч даван туулагчид үйлчилгээ үзүүлэх чиглэлээр чадавхажсан байна. 2021 оны 2 дугаар сарын байдлаар нийт 38 хүн үйлчилгээ үзүүлсэн.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн бүртгэлийн программын II шатны шинэчлэлийн бэлтгэл ажил хангах хүрээнд 2019, 2020 онд Хөвсгөл аймагт шилжсэн 92 дуудлагыг мэдээллийг оруулж, шийдвэрлэлтийг ханган ажиллав.

Гэр бүлүүдэд тулгамдаж буй асуудлуудыг тодруулж, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ авах хэрэгцээ шаардлага иргэдэд байгаа эсэхийг илрүүлэх “Гэр бүл ба шийдэл” судалгаанд 2801 гэр бүлүүд хамрагдсан байна.

Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр 11 насанд хүрэгч, 2 хүүхэд нийт 13 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс 6 эрэгтэй, 5 эмэгтэй байна. Сэтгэл зүйн зөвлөгөөг биечлэн 10, утсаар 2, цахимаар 1 хүнд тус бүр үзүүлсэн байна.

Хөвсгөл гэр бүлийн радио 104,5-тай хамтран хуваарийн дагуу 5 мэргэжилтэн, аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүн 2 хүүхэд оролцож, 5 сэдвийн хүрээнд мэдээлэл өгч 105 хандалт авсан байна.

Цахим хэлбэрээр зохион байгуулагдсан 3 төрлийн уралдаанд 55 хүүхэд, 6 насанд хүрэгч оролцож, эдгээрээс 23 хүүхэд, 4 насанд хүрэгчийг шалгаруулж урамшуулав. Шилдэг оролцогчдын бүтээлийг иргэд олон нийтэд хүргэх ажлыг цахимаар зохион байгуулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, Шүүхийн журмаар баривчлагдсан иргэдэд аймгийн Цагдаагийн газартай хамтран 2021 оны 1 сарын 15-ны өдрөөс 3 дугаар сарын 31-ны өдөр хүртэлх хугацаанд сургалт зохион байгуулах хуваарийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уг сургалтыг аймгийн ЦГ-аас 2 албан хаагч, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 8 албан хаагч тус тус зохион байгуулж байна.

2021 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 36 тоот албан бичгээр чиглэл, зөвлөмж, гарын авлагыг 24 сум, 47 агентлаг байгууллагад хүргүүлэн ажиллав. Мөн аж ахуйн нэгж, томоохон үйлчилгээний төвүүдэд хүргэхээр ажиллаж байна. Байгууллагын дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн гарын авлага боловсруулж, 100 ширхгийг хэвлүүлэн хүргэв.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Нийгмийн халамжийн нэгдсэн систем /ЕНАЛАМJ.mn/-ээр 24363 иргэнд 2,2 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг иргэний арилжааны банканд дахь дансны хоболт хийснээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас шууд олголтыг хийн ажилласан. ЕНАЛАМJ.mn-ээр доорх үйлчилгээг иргэний хүсэлтийг цахимаар авч шийдвэрлэсэн.

Мөрөн сумын 7 дугаар багт байрлах ахмадын амралтын газар 2021 оны 2 дугаар сарын 20-нд эхлэн 12 ахмад хүлээн авч амраан сувилж байна

Ажлын байранд **36** иргэн зуучлагдан ажилд орсон. Идэвхтэй ажил хайгчаар **329** иргэн бүртгэгдсэн. Шинэ ажлын байр 64 бий болсон бөгөөд байнгын ажлын байр 36, улирлын 3, түр 25 байна.

СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

“Иргэдийн оролцоонд тулгуурласан өв хамгаалал” хөтөлбөрийг цахим хичээл болгон Facebook-т байршуулсан бөгөөд 1000 гаруй хүн үзсэн байна.

Боловсрол шинжлэх ухааны 100 жилийн ойд Хөвсгөлийн 11 алдартны материалыг бэлтгэн өглөө.

7 Сургуулийн цахим номын сангийн тоног төхөөрөмжийг гардуулан өгч, Мэдээлэл бэлтгэн олон нийтэд сурталчиллаа.Соёлын өвийн үндэсний төвийн улсын хамгаалалтад авах үл хөдлөх дурсгалын саналыг аймгийн удирдлагуудад танилцуулав.

“Цахим орчинд соёл түгээе” Ковид-19 буюу коронавирусын цар тахлын 2 дугаар давалгаа үүссэнтэй холбогдуулж бүх нийтийн бэлэн байдалд шилжин ажиллалаа. Соёлын яамнаас уриалж буй цахим орчинд соёл түгээе. “Би хариуцлагатай иргэн” аяныг байгууллага дээр өрнүүлэн ажиллаж байна. Уран бүтээлчид аянд нэгдэхдээ өөрийн уран бүтээлээ байгууллагын фейж хуудсаар дамжуулан шууд лайв тоглолтыг зохион байгуулсан.

Хөгжимт драмын театр, Орон нутаг судлах музей, Нийтийн номын сан, Боловсрол, соёл урлагийн газар хамтран “Охин хүнийг хүнд өгдөг болсны учир” танин мэдэхүйн нэвтрүүлгийг бэлтгэж байна. Нэвтрүүлэг нь Хөвсгөл нутгийн өв соёл, зан заншил, аж байдлыг танин мэдэх, ирээдүйн хүүхэд залуучуудад таниулах зорилгоор салбарууд хоорондоо нэгдэж “ЗАН ЗАНШИЛ”-ын домог үлгэрээр нэвтрүүлэг бэлтгэж хүргэлээ.

ОРОН НУТАГ СУДЛАХ МУЗЕЙ:

Хөвсгөл аймгийн Цаатан, Дархад угсаатны хэрэглэж байсан эд өлгийн зүйлээр 3 удаа, Түүх соёлын үл хөдлөх дурсгал болох Буган чулуун хөшөөний талаар “ЦАХИМ МУЗЕЙ” сэдэвт бичлэг хийн “Хөвсгөл музей” пэйж хуудсаар 4 удаа танилцуулж нийт 7 сэдэвт бичлэг хийсэн.

Сан хөмрөг үзүүлэг дахь дулаан, чийгшлийг хянах багаж суурьлуулж судалгааны ажлыг эхлүүлсэн.

Рашаант сумын Орон нутгийг судлах танхимын цуглуулгыг улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэх ажил хийгдлээ.

НИЙТИЙН НОМЫН САН:

Сонсдог ном үйлчилгээ 698 уншигчдад хүрч үйлчиллээ. Томруулдаг шил булангаар Хөвсгөлийн домгуудаас түүвэрлэн 1462 уншигчид хүргэлээ. Танин мэдэхүйн нэвтрүүлэг болох “Өв” соёл нэвтрүүлгийг соёл урлагийн байгууллагуудтай хамтран хүргэж 785 уншигчдад хүргэж мэдлэг олгосон байна.

СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Олон улсын хэмжээний 1 сургалтад , улсын хэмжээний 4 сургалтад Биеийн тамир спортын газрын 20 хүн, 21 багш арга зүйч хамрагдлаа.

Орон нутгийн хэмжээнд сургалт семинарыг орон тооны болон орон тооны бус арга зүйчдийн дунд үе шаттайгаар зохион байгуулж 20 байгууллагын 25 хүн хамрагдлаа.

Цахим сургалтад 7 төрлийн спортоор дасгалжуулагчид нийт 53 өсвөр үеийн тамирчдыг хамруулж ажиллаж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Барут Марк хотоос “Мөрөн хотод зориулсан цар тахлын эсрэг тусламж” төслийн хүрээнд зарим төрийн байгууллагуудад "Ковид-19 халдварын тухай ойлголт, урьдчилан сэргийлэлт, сэтгэл зүйгээ дэмжих" сэдвээр ЭМГ-аас сургалт зохион байгууллаа. Мөрөн сум, Эрүүл мэндийн газар хамтран 180 эрүүл мэндийн ажилтан, сайн дурын идэвхтэн нарыг чадваржуулах сургалтыг зохион байгууллаа.

ЭМГ-аас “Маскаа зүүе-Гараа угаая” аяны хүрээнд Мөрөн сумын 13 дугаар багаар явж зорилтот өрхийн нийт 72 хүүхдэд амны хаалтыг зөв зүүх, гараа тогтмол зөв угаах талаар мэдээлэл өгч, амны хаалт, гарын ариун цэврийн багц өгсөн. Мөн Мөрөн сумын 10,11 дүгээр багийн зорилтот өрхийн 32 хүүхдэд амны хаалтыг зөв зүүх, зөв тайлах, гараа зөв угаах, хэзээ гараа угаах талаар сургалт хийж, хүүхэд бүрт амны хаалт, “Гарын ариун цэврийг сахихад дэмжлэг үзүүлэх багц”, гар угаах дараалал, амны хаалт зөв зүүх, мэдээлэл сурталчилгааны материал өгч ажиллав.

Улсын Онцгой комиссоос чиглэл болгосны дагуу аймгийн Онцгой комисс Нийслэлийн Онцгой комисстой хамтран Улаанбаатар хотод хөл хорионд орсон орон нутгийн иргэдийг татан авах ажлыг зохион байгуулсан.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс ирүүлсэн “Архидан согтуурахаас сэргийлье” цахим сурталчилгааны аяныг зохион байгуулах удирдамж, F10 оноштой иргэдийн судалгааг ирүүлэх тухай ЭМГ-ын 319 тоот албан бичгийг ЭМБ-дад хүргүүлэн ажиллалаа.

Коронавирусийн цар тахалтай холбоотойгоор Эрүүл мэндийн байгууллагуудын ажлын үр дүнг цахимаар үнэлсэн. Үнэлгээг Эрүүл мэндийн сайдын А/422-дугаар тушаал, Засгийн газрын 82 дугаар тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлалаар дүгнэсэн.

“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, төлөвшил, хариуцлага” эрдэм шинжилгээ, онол практикийн улсын анхдугаар хурал болж Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооны гишүүд цахимаар оролцоо. АЗДТГ-ын Архивын тасгаас зохион байгуулсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Архивын ерөнхийн газраас зохион байгуулсан “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах арга зүй” сэдэвт мэргэшүүлэх сургалтад архив албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан цахимаар хамрагдсан.

Эрүүл мэндийн газар 2021 онд Олон улсын Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэхээр "Ворлд стандарт консалтинг " ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгууллаа

ХЯНАСАН:

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.АРИУНБАТ**

НЭГТГЭСЭН:

**ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРМАА**